

ОЮУТНЫ БИЕ ДААХ АЖЛЫН НЭГЭН ХУВИЛБАР

А.Буянжаргал, ОТИС, Б.Жаргалсайхан, доктор, МУБИС

Abstract

In Mongolia the Tertiary education has been reformed intensively. The main objective of preparing a specialist who can meet the international requirements is providing an employee with self-learning skill. Another main point of higher education is to let students possess the self-learning ability, skill, and practice. In order to achieve that purpose, students should study on variety of tasks to possess skills of self-learning on many activities at the same time.

It is important to practice it in real life, after student possessed the self-learning skill during the education operation. Student's self-learning process is not only important part of university but also it is the superior form of learning.

In education practice of recent days, many researches shows that students do the assignments for only presenting to lecturers to get points. This can affect negatively to student's professional – individual formation. Therefore we need to pay attention more on improving the effectiveness of assignments and refining the teaching methodology and types.

This article presents how to organize assignment of chemistry lectures, laboratory, and practical training classes. Also, it will introduce the outcome and method of a version of joint assignments of general and specialized subjects and its implementation in the examples of chemistry lecture, laboratory and practical training.

Түлхүүр үг

Сурах чадвар, суралцаж сурахуй, сурах үйл, оюутны үнэлгээ

Удиртгал

Судалгааны их сургуулийг хөгжүүлэх сургалтын нэг чухал зорилго нь суралцагчдад бие даан суралцах чадвар эзэмшүүлэх, асуудалд шүүмжлэлтэй хандах чадварыг төлөвшүүлэхэд чиглэдэг билээ. Монгол Улсын Боловсролын тухай хуульд боловсролын зорилгыг “Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” (Боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1) хэмээн заажээ. Иймээс дээд боловсролын агуулга нь нэгдмэл байхын зэрэгцээ бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэх мэдлэг, чадвар дадал эзэмшүүлэхэд чиглэгдэнэ гэсэн байдаг (Дээд боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйл 3.1). Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхэд оюутны бие даасан ажлыг зохион байгуулах үйл ажиллагаа нь нэн тэргүүний үүргийг гүйцэтгэнэ.

Суралцагчдад бие даан суралцах чадвар төлөвшүүлэх асуудлыг үе үеийн сурган хүмүүжүүлэгч эрдэмтэд тал бүрээс нь судалсаар ирсэн билээ. XV-XX зууны нэрт сурган хүмүүжүүлэгч, эрдэмтдийн тухайлбал, Швейцарын эрдэмтэн сэтгэл судлаач Ж.Пиаже, ОХУ-ын нэрт эрдэмтэн Л.Выготский болон тэдний шавь нарын хөгжүүлсэн онолоор хүн өөрийн бүтээлч үйл ажиллагаагаар мэдлэгийг бүтээнэ хэмээн үзсэн байдаг.

Сурах үйлийг хувь хүний мэдлэг, чадвар

дадал соёлын үнэт зүйлийг эзэмших, шинэ хандлагаар төлөвших үйл явц, харин суралцах гэсэн ухагдахууныг идэвхтэй сурах үйл гэсэн өргөн утгаар авч үздэг. Сурах чадвар гэдэг нь аливаа зүйлд бие даан бүтээлчээр үр ашигтай арга барилаар, хурдтай суралцах чадвар юм (Батаа, 2013, х.2).

Үндсэн хэсэг

Их, дээд сургуулийн сургалт үндсэндээ оюутны бие даасан үйл ажиллагаанд тулгуурлан явагдаж байна. Оюутны бие даах ажил гэдэг нь сургалтын стандарт, хөтөлбөр нөгөөтээгүүр оюутны сонирхол, чадавх зэргийг харгалзсан хичээлийн болон хичээлийн бус цагаар багшийн шууд бус удирдлага дор явагддаг оюутны бие дааж суралцах бүтээлч үйл ажиллагаа юм (Бурмаа ба бус, 2003). Мөн оюутанд бие дааж суралцах арга барил, чадвар, дадал эзэмшүүлэх нь боловсролын гол зорилго болоод байна. Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд оюутанд сурах олон талт үйл үйлдлийг бие дааж хийх арга барил эзэмшүүлэх даалгавруудыг бүтээлчээр хийлгэх замаар ажилладаг байна.

Оюутны бие даалтын ажлын ач холбогдол: Хичээлийн явцад бүрэн эзэмшээгүй зүйлээ бүрэн гүйцэд өөрийн болгох, мэдлэгээ гүнзгийрүүлэх, авьяас чадавхаа нээн хөгжүүлэх, бие дааж сэтгэн бодох, өөрийнхөө үйл ажиллагааг зохион

байгуулах, төлөвлөх, хянан жолоодох, бие дааж оновчтой шийдвэр гаргах, дүгнэлт хийх, зөрчилт байдлаас гарах арга барил эзэмших, хариуцлагатай байх, багаар ажиллах, хамтрах, цаг барих зэрэг олон талын арга барил эзэмших явдал юм.

Бие даан суралцахуй гэдэг нь бусдын тусламжтай болон тусламжгүйгээр суралцах идэвх санаачлага, сурах хэрэгцээ, зорилгоо тодорхойлох, сурах үйлд шаардлагатай материаллаг болон бусад нөөцийг таних, оновчтой суралцах арга барилуудыг сонгон хэрэглэх, суралцах үйл ажиллагааны үр дүнгээ үнэлэн дүгнэх үйл явц бөгөөд өөрийгөө удирдан жолоодох, хянах, үнэлэх, суралцагчдад өөрсдийн сурах үйлд илүү хариуцлагатай байх чадвар юм.

Эрдэмтэн Д.Р.Гаррисон бие даан суралцах үйлийг уламжлалт сургалтын үйлтэй харьцуулан дараах байдлаар загварчилсныг бүдүүвч 1-д үзүүлээ. (Carolyn H. Hopfer, 2001)

Зураг 1

Уламжлалт сургалтын үйл ба бие даан суралцах үйлийн харьцуулсан загварчлал



Зураг 1-д уламжлалт сургалтын үед бие даан суралцах сургалтыг суралцагчийг таних, сургалтаа төлөвлөх, явуулах, үнэлэх байдлаар явуулж байсан бол орчин үед бие даан суралцах нь өөрийгөө таньж мэдэх, хувийн менежмент зохион байгуулалт хийх, хэрхэн сурах арга барилд суралцахаа ойлгох, өөрийн хийсэн зүйлдээ үнэлж дүгнэх байдалтай болсныг харьцуулан илэрхийлсэн байна.

Бие даалтын ажил нь мэргэжлийн онцлогоос хамаарч янз бүрийн хэлбэртэй байж болох бөгөөд сургалтын агуулга, цагийн хэмжээ, суралцагчийн ачаалал, сургалтын орчин нөхцөл зэргээс хамааруулан, түүний хүнд хөнгөнийг тохируулан өгөх шаардлагатай.

Иймээс бие даалтын ажлын бүтэц, загварыг сургууль тус бүр өөрийн сургалтын онцлогоос хамааран янз бүрээр өгдөг.

Бие даалтын хэлбэрийг ихэвчлэн тухайн хичээлийн агуулга, ур чадвараар нь олон янзын хувилбараар ангилсан байдаг.

Бүдүүвч 1

Оюутны бие даалтын ажлын түвшин

Сэргээн хуулбарлах: мэдлэгийг таних, ухамсарлах, тогтоох үйл ажиллагааг гүйцэтгэхэд чиглэнэ. Үүнд: даалгавар, дасгал гүйцэтгэх, бодлого бодох, мэдээлэл хийх, хүснэгт хийх, график зурах ...



Өөрчлөн хувиргах: мэдлэгээ өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх арга барил, чадвар олгох явдал юм. Энд уншсан зүйлийн төлөвлөгөө зохиох, тодорхой асуудлаар өөрийн санаа бодлоо найруулан бичих, эссэ бичих, бодлого зохиох, реферат бичих, илтгэл бичих...



Бүтээлч: тодорхой үзэгдэл, асуудал, нөхцөлд тодорхойлолт өгөх, асуудлыг шийдвэрлэх арга зам, хэрэглэгдэхүүнийг бие дааж сонгож авах, шинэ мэдлэг бүтээх, сурах арга барилыг олгох явдал юм. Энд шийдвэрлэх асуудлыг олуулах, түүнийг хэрхэн шийдэх талаар эрэл хайгуул хийлгэх, төсөл боловсруулах, судалгаа хийх, судалгааны баримт материал болон ном зохиолд боловсруулалт хийх, тайлан бичих, ангийн ажил болон дипломын ажил хийх, илтгэл хэлэлцүүлэх...

Оюутны бие даалтын ажлын сэдэв нь ерөнхийдөө заавал хийх, сонгож хийх, сонирхсон сэдвээ судлах гэсэн хэлбэртэй байх ба суралцагчдын цаашдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, практик ач холбогдолтой, тулгамдсан асуудалд өөрийн байр сууринаас шүүмжлэлтэй хандах чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн даалгаврууд байх нь илүү ач холбогдолтой юм.

Сэдэв бүрийн эцэст оюутан бие дааж энгийн ажиглалт хийх, шаардлагатай ном, сэтгүүл уншиж тэмдэглэл хөтлөх, зохих хүмүүсээс ярилцлага, асуулга авах, төрөл бүрийн бүтээлч асуулт, даалгавар өгөх, асуулт, төлөвлөгөө, бодлого зохиох, тодорхой юмс үзэгдэлд анализ хийх, орчуулга хийх, мэдээлэл технологийн олон талт хэлбэрийг ашиглан мэдээлэл олж авах ажлыг бие даан хийх, багаар хамтран гүйцэтгэхээр тусгаж болно.

Бие даалтын ажлыг үнэлэхдээ өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дараах арга хэлбэрийг харгалзан үздэг.

Үүнд:

1. Оюутны өөрийн үнэлгээ
2. Бусад оюутны /чацуутны/ үнэлгээ
3. Багшийн үнэлгээ

Өнөө үед оюутанд бие дааж суралцах арга барил, чадвар, дадал эзэмшүүлэх нь сургалтын гол зорилго болоод байгаа бөгөөд энэхүү зорилго нь мөн оюутны бие даалтын ажлын үндсэн зорилт болж оюутанд сурах олон үйл, үйлдлийг бие дааж хийх арга барил эзэмшүүлэх хэрэгтэй гэдгийг харуулж байна.

Бид химийн хичээлээр бие даалтын нэгэн хувилбарыг боловсруулан хэрэгжүүлсэн байдлыг танилцуулъя.

Хичээлүүдийн хамтарсан бие даалтын ажлыг даалгаврыг шинжлэн судлах технологийг хэрэгжүүлэх үе шатуудтай (Сумъяа, Буянжаргал, 2013, х.75) уялдуулан өгсөн болно.

Бие даалтыг гүйцэтгэхдээ багшийн санал болгосон сэдвүүдээс оюутан сэдвээ сонгон авч, сонгосон сэдвийнхээ дагуу дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Үүнд:

- Өгөгдсөн даалгаварт задлан шинжилгээ хийх
- Сэдвийнхээ зорилгыг тодорхойлж, таамаглал дэвшүүлэх
- Тухайн даалгаврыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах
- Төлөвлөгөөний дагуу даалгаврыг гүйцэтгэх
- Баримт материал цуглуулах
- Цуглуулсан мэдээллийг боловсруулах
- Шалтгаан үр дагаврыг тодорхойлох
- Дүгнэлт гаргах
- Тайлан бичих
- Хэлэлцүүлэх

Хамтарсан бие даалтын ажлыг гүйцэтгэхийн тулд хичээлийн жилийн эхэнд багш нарын баг бүрдүүлэн хамтарсан бие даалтын ажил хийх сэдвийг боловсруулан батлуулах, бие даалтын ажлын зорилго, зорилт, тоо, төрлийг урьдчилан боловсруулж тэдэнд танилцуулан эдгээрийг яаж хийх заавар зөвлөгөө өгөх, ашиглах ном, бусад хэрэглэгдэхүүн, тавигдах шаардлага, бие даалтын ажлаа хэдийд өгөх хугацаа, ажлын явц, гүйцэтгэл зэргийг яаж хянаж туслах, хэрхэн үнэлүүлж, дүгнүүлэх талаар тодорхой боловсруулан оруулсан байх нь зүйтэй.

Хамтарсан бие даалтын хичээлийг гүйцэтгэхдээ оюутан багш нарын багийн хийх ажил

- Зорилго, зорилтоо тодорхойлох
- Өөрсдийн заадаг хичээлүүдийн хөтөлбөрт тусгагдсан сэдвүүдээс хамтарсан бие даалтад өгөх сэдвүүдийг сонгох
- Сонгосон сэдвүүдийнхээ талаар гүйцэтгэх даалгавруудыг гаргах
- Багш нарын санал болгосон даалгавруудын хоорондын уялдаа холбоог тогтоох
- Тогтсон сэдвүүдийн дагуу гүйцэтгүүлэх даалгавруудыг гаргах
- Оюутанд өгөх бие даалтын ажлын заавар бэлтгэх
- Бие даалтын ажил гүйцэтгэх явцад зөвлөн туслах
- Хэлэлцүүлэг хийх
- Бүтээлийн сан бүрдүүлэн, засан сайжруулах
- Үр дүнг илтгэн хэлэлцүүлэх

Энэхүү судалгааны зорилго нь хамтарсан бие даалтын ажлаар химийн хичээлүүдийн бие даалтын ажлын үр нөлөө, ач холбогдлыг дээшлүүлэх явдал байсан юм.

“Органик хими ба Аналитик химийн хичээлийн хөтөлбөрийн агуулга уялдааг харгалзан хамтарсан нэг бие даалтын сэдэв боловсруулан Технологийн дээд сургуулийн ХТИ 1а туршилтын бүлэг болгон оюутнуудад бие даалт өгөн үр дүнг судалж үзсэн.

Хяналтын бүлгийн /ХҮҮТ1а/ оюутнуудын гүйцэтгэсэн бие даалтын ажил болно.

Жишээ нь: Туршилтын бүлэгт (ХТИ1а) “Органик хими ба Аналитик химийн хичээлийн хөтөлбөрийн агуулга уялдааг харгалзан хамтарсан нэг бие даалтын сэдэв өглөө.

Бие даалтын ажлын сэдэв: *Органик нэгдлийг химийн анализад хэрэглэх нь*

Төлөөлөл нь: *Этаны хүчил /Цууны хүчил, /*


Энэ бие даалтын ажлыг хийснээр танин мэдэх үйл ажиллагааны түвшин ахих тутам оюутнуудад төлөвших чадварууд нэмэгдэн бүтээлч түвшний туршилтын судалгааны арга барил эзэмшүүлэх чиглэл нь илүү хөгжино.

Иймээс бүтээлч үнэлгээний даалгавар боловсруулж бүтээлч түвшний загвараар төлөвших чадваруудыг харьцуулан гаргалаа.

Тухайлбал:

1. Сонгосон сэдвийнхээ утга санааг томьёолсон байдал
2. Ямар туршилт судалгаа гүйцэтгэхээр төлөвлөсөн бэ?
3. Сонгосон органик нэгдлийнхээ бүтцийн томьёог бичиж, тооны ба чанарын найрлагыг тодорхойлно уу?
4. Туршилтын үр дүнгээ бичнэ үү?
5. Ашигласан мэдээллийн эх сурвалжаа бичнэ үү? гэсэн асуулт даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлд анализ хийн, үр дүнг диаграмм 1-д харууллаа.

Диаграмм 1



Диаграмм 1-ээс үзэхэд хичээлүүдийн хамтарсан бие даалтын ажлыг гүйцэтгэсэн ангийн суралцагчдын гүйцэтгэлийн хувь нь хяналтын ангиас 3.68-25.62%-аар илүү гүйцэтгэлийн үнэлгээтэй байгаагаас харагдаж байна. Мөн гүйцэтгэсэн бие даалтын ажлын аль түвшний

ажлыг хэрхэн хийж гүйцэтгэсэн байдалд анализ хийн дүгнэлээ.

Хяналтын бүлэг буюу ХҮҮТ1а ангийн оюутнуудын бие даалтын гүйцэтгэлийг дүгнэн хувиар илэрхийлж хүснэгт 1 болон диаграмм 2-д харуулав.


Хүснэгт 1

Хяналтын бүлгийн үр дүн

Бие даалтын гүйцэтгэл	Танин мэдэх даалгаварт задлан шинжилгээ хийсэн байдал	Таамаглал дэвшүүлсэн эсэх	Туршилт хийх төлөвлөгөө гаргасан эсэх	Туршилт гүйцэтгэсэн байдал	Туршилтын үр дүнг боловсруулсан байдал
Сэргээн хуулбарлах түвшний даалгаврын гүйцэтгэл	49.4	48.71	58.7	50	29.4
Өөрчлөн хувиргах түвшний даалгаврын гүйцэтгэл	17.9	22.4	-	26.9	14.1
Бүтээлч түвшний даалгаврын гүйцэтгэл	9.3	5.4	-	-	-
Гүйцэтгээгүй	23.5	23.49	41.3	23.1	56.5

Хүснэгтээс үзэхэд оюутнуудын сэргээн хуулбарлах түвшний даалгаврын гүйцэтгэл илүү сайн байгаа ба өөрчлөн хувиргах, бүтээлч түвшний даалгаврын гүйцэтгэл хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Диаграмм 2
Хяналтын бүлгийн үр дүн




Диаграмм 2-оос үзэхэд 47.24% нь сэргээн хуулбарлах буюу лекц семинараа нэмэн дэлгэрүүлсэн, 16.26% нь өөрчлөн хувиргах буюу мэдлэгээ өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх, 2.94% нь бүтээлчээр, 33.58% нь хангалтгүй бие даалтын ажлаа гүйцэтгэсэн байна. Туршилтын /ХТИ1а/ ангийн оюутнуудын бие даалтын гүйцэтгэлийг хувиар илэрхийлэн хүснэгт 2 болон диаграмм 3-д үзүүлэв.

Хүснэгт 2
Туршилтын бүлгийн үр дүн

Даалгаврын гүйцэтгэл	Танин мэдэх даалгаварт задлан шинжилгээ хийсэн байдал	Таамаглал дэвшүүлсэн эсэх	Туршилт хийх төлөвлөгөө гаргасан эсэх	Туршилт гүйцэтгэсэн байдал	Туршилтын үр дүнг боловсруулсан байдал
Сэргээн хуулбарлах	53.2	26.3	46.1	40.9	51.3
Өөрчлөн хувиргах	23.7	39.4	15.4	28.2	35.5
Бүтээлч	10.2	34.3	7.35	21.1	13.2
Гүйцэтгээгүй	12.9		31.15	9.8	

Диаграмм 3
Туршилтын бүлгийн үр дүн




Диаграммаас үзэхэд 43.56% нь сэргээн хуулбарлах буюу лекц семинараа нэмэн дэлгэрүүлсэн, 28.44% нь өөрчлөн хувиргах буюу мэдлэгээ өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх, 17.23% нь бүтээлчээр, 10.77% нь хангалтгүй бие даасан ажлаа гүйцэтгэсэн байна.

Хяналтын болон туршилтын бүлгийн бие даалтын ажлын гүйцэтгэлийг хувиар илэрхийлэн харьцуулсан дүнг диаграмм 4-д харуулав.

Диаграмм 4

Хяналтын болон туршилтын бүлгийн үр дүнгийн харьцуулалт



Диаграммаас үзэхэд сэргээн хуулбарлах буюу лекц семинараа нэмэн дэлгэрүүлсэн нь 47.24%-аас 43.56% болж, хангалтгүй гүйцэтгэсэн бие даалтын ажил нь 33.58%-аас 10.77% болж тус тус буурсан бол өөрчлөн хувиргах буюу мэдлэгээ өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэх нь 16.26%-аас 28.44% болж, бүтээлч бие даалт нь 2.94%-аас 17.23% болж тус тус өссөн байна. Бие даалтын ажлын нэгэн хувилбарын жишээг доор дурдан оруулав.

Оюутанд өгөх бие даалтын ажлын зааврын загвар

1. Сэдэв: Кофе бэлтгэх
2. Даалгавар:
 - Кофе бэлтгэх технологи
 - Кофений хөөсний ач холбогдол, хөөсний найрлага, шинж чанар
 - Кофе чанах үед хэдийд нь хөөс үүсдэг вэ?
 - Кофег бэлтгэх үед физик ба химийн ямар процесс явагдах вэ?
 - Кофений амт, үнэр үүсгэгч бодисуудыг хадгалах үед ямар нөхцлийг бүрдүүлдэг вэ?
 - Кофег чанах орон орны онцлог аргууд
 - Хандлагдах процесст усны хатуулаг ямар нөлөө үзүүлэх вэ?
 - Хандлалтын үр дүнг дээшлүүлэхийн тулд сахароз ямар үүрэгтэй вэ?
3. Даалгаврыг гүйцэтгэх дараалал
 - Өгөгдсөн даалгаварт задлан шинжилгээ хийх
 - Сэдвийнхээ зорилгыг тодорхойлж, таамаглал дэвшүүлэх
 - Тухайн даалгаврыг гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах
 - Төлөвлөгөөний дагуу даалгаврыг судлах
 - Баримт материал цуглуулах
 - Цуглуулсан мэдээллийг боловсруулах
 - Шалтгаан үр дагаварыг тодорхойлох
 - Дүгнэлт гаргах
 - Тайлан бичих
 - Хэлэлцүүлэх
4. Хамгаалах хугацаа: он, сар, өдөр
5. Хамрах хичээл: Хоол үйлдвэрлэлийн технологи, физик коллойд хими, мэдээллийн технологи
6. Үнэлгээ: Хийсэн даалгаврынхаа явц болон гүйцэтгэлийн талаар өөрийн болон хамтран

суралцагч оюутны дүгнэлт санал зөвлөмжийг хавсаргасан байна.

7. Хэлэлцүүлэгт бэлтгэхэд тавигдах шаардлага болон анхаарах зүйл

Химийн хичээлээс гадна математик, физик, гадаад хэл, мэдээллийн технологи, хоол үйлдвэрлэлийн технологи, экологи байгаль хамгаалал, биологи зэрэг хичээлүүдийн агуулгатай тохируулан хамтарсан бие даалтын ажлыг гүйцэтгүүлэх боломжтой юм.

Бид химийн хичээлийн хувьд хамтарсан бие даалтын ажлыг 1 улирлын туршид оюутны бие даалтын ажлыг гүйцэтгүүлэн өөрсдийн туршилтын дүнг үндэслэн дүгнэлт хийлээ.

Дүгнэлт

- Хичээлүүдийн хамтарсан бие даалтын ажлын нэгэн хувилбарыг хэрэгжүүлснээр оюутнууд хичээл хоорондын уялдааг таньж мэдэх, оюутан аливаа зүйлд нэг талаас биш олон талаас дүн шинжилгээ хийх бүтээлч сэтгэлгээ хөгжих давуу талтай.
- Багшийн хувьд хичээлийн хөтөлбөрийн агуулгаа багцлах, цаг хэмнэх, бие даалтын ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.
- Орчин үеийн дээд боловсролын шаардлага хангасан мэргэжилтэн бэлтгэх боловсролын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд бие дааж ажиллах, амьдрах, суралцах чадвар эзэмшсэн мэргэжилтэн бие хүн төлөвшүүлэхийн тулд оюутны бие даалтын ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга, хэлбэрийг шинэчлэн сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Зөвлөмж

- Оюутнуудад өгч байгаа бие даалтын ажлын чанар үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд өөрсдийн заадаг хичээлүүдийн агуулгын уялдааг харгалзан үзэж, нягтруулж, уялдуулж бие даалтыг хамтарсан хэлбэрээр явуулах, туршин сайжруулах, үр дүнг хэлэлцүүлэн бүтээлийн сан бүрдүүлж ажиллахыг эрдэмтэн багш та бүхэнд зөвлөж байна.
- Их, дээд сургуулийн сургалтын ихэнх хувийг оюутны бие даалтын ажил хийлгэх, оюутнуудыг бие даан суралцах чадвартай болгон төлөвшүүлэхэд чиглэгдэж байгаа орчин үеийн сургалтын шаардлагыг хангахын тулд багш бид оюутны бие даалтын ажлын арга хэлбэрийг сайжруулах нэг арга зам хичээлүүдийн хамтарсан бие даалтын ажлын хувилбар байж болохыг санал болгож байна.
- Хичээлийн зорилготой уялдсан, олон талт чадвар төлөвшүүлэхүйц, агуулгын багтаамж тохирсон, танин мэдэхүйн дээд түвшний үйл ажиллагаанд татан оруулсан байхад чиглэсэн байх нь зүйтэй байна.
- Бие даалтын ажлыг хэрхэн хийх аргачлалыг тодорхойлох, амьдрал практиктай холбох, асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн, өгөгдсөн даалгавартаа тохирсон оноотой байх, залгамж холбоотой байж шалгалтад тодорхой хэмжээгээр тусгадаг байх
- Бие даалтын удирдамжийг багш бүр хичээл бүр дээр гаргаж оюутнуудад танилцуулдаг байх /тарааж өгдөг байх/
- Бие даалтын сэдэв оюутан өөрөө сонгон хийх боломжтой олон хувилбартай байх
- Бие даалтыг хэрхэн хийх, хэрхэн үнэлүүлэх мэдээлэл нь ил тод зарчимд тулгуурласан байх

Ашигласан материал

Улсын Их Хурал. БСШУЯ Боловсролын тухай
хуулийн 4 дүгээр зүйл 4.1

Улсын Их Хурал. Дээд боловсролын тухай
хуулийн 3 дугаар зүйл 3.1

Батаа, Б. (2013). Сурагчдын бие даан
суралцах чадварыг хөгжүүлэх арга
зам Улаанбаатар

Бурмаа, Б., ба бус. (2003). Багш боловсролын
хөгжлийн шинэ чиг хандлага (стандарт
киррикулимийн онол, арга зүй).
Улаанбаатар

Carolyn, H.Hopper. (2001). *Practicing college
Learning Strategies*

Сумъяа, Ц. Буянжаргал, А. Судалгааны их
сургуулийг хөгжүүлэхэд шинжлэн
судлах технологийг хэрэглэх асуудалд.
Дээд боловсролын шинэчлэл-сургалтын
технологи. Улаанбаатар